



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 9/125

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, 30 дугаар зүйлийн 30.2, 30.3, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн голомтод авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг олон нийтэд шуурхай хүргэх зорилгоор "Нийслэлийн Онцгой байдлын газар" гэсэн нэр бүхий фэйсбүүк хуудсыг ажиллуулах журмыг хавсралтаар баталсугай.
2. Шуурхай албаны автомашин, шаардлагатай техник хэрэгслээр ханган ажиллахыг Санхүү эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т даалгасугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (дэд хурандаа Н.Нямхорлоо) -д үүрэг болгосугай.

ДАРГА,  
ХУРАНДАА  
  
Ж.ЧҮЛТЭМСҮРЭН  
1117155601  
УХА0038 9077073

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын  
2019 оны 11 дүгээр сарын 06.-ны өдрийн  
07/145 дугаар тушаалын хавсралт

1117155601  
УХА0038 9077073

## НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ФЭЙСБҮҮК ХУУДАС АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1. Энэхүү журам нь Нийслэлийн Онцгой байдлын газрын гамшгаас урьдчилан сэргийлэх, гол түймэр унтраах, аврах ажиллагааны мэдээ, мэдээлэл, гамшгаас урьдчилан сэргийлэх сээрэмжлүүлгийг олон нийтэд шуурхай хүргэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Нийслэлийн Онцгой байдлын газрын фэйсбүүк хуудсанд мэдээ мэдээллийг тухай бүр шинэчлэн, гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж буй удирдагч, орлогч, Гамшгаас хамгаалах болон Гол түймрийн улсын хяналтын байцаагч, нийслэлийн Аврах анги 105 –ийн захирагч, бүлгийн дарга, Гол түймэр унтраах, аврах ангийн захирагч, Салааны захирагч, дүүргүүдийн Сургалт, урьдчилан сэргийлэх, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн нар хөтөлнө.

Хоёр. Фэйсбүүк хуудас хөтлөгчийн үүрэг

2.1. Фэйсбүүк хуудас хөтлөгч нь дараах үүрэгтэй.

2.1.1. Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж буй буй удирдагч, орлогч, Гамшгаас хамгаалах болон Гол түймрийн улсын хяналтын байцаагч, нийслэлийн Аврах анги 105 –ийн захирагч, бүлгийн дарга, Гол түймэр унтраах, аврах ангийн захирагч, Салааны захирагч, дүүргүүдийн Сургалт, урьдчилан сэргийлэх, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн нар гол унтраах, аврах ажиллагааны зураг болон дүрсийг шууд видео хэлбэрээр олон нийтэд хүргэх. / гар утас ашиглан /

2.1.2. Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн голомтод нөхцөл байдал болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнээс өөр зүйл нэвтрүүлэхийг хориглох.

2.1.3. Мэдээ мэдээллийг түгээхдээ Гамшгаас хамгаалах тухай болон Онцгой байдлын албанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журмууд, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулинд нийцүүлж ажиллах.

**Гурав. Олон нийтэд мэдээллийг шуурхай хүргэх зохион байгуулалт**

3.1. Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшигийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа буй удирдагч, орлогч, Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын байцаагч, нийслэлийн Аврах анги 105 –ийн захирагч, бүлгийн дарга, Гал түймэр унтраах, аврах ангийн захирагч, Салааны захирагч, дүүргүүдийн Сургалт, урьдчилан сэргийлэх, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн нар гар утсаараа нөхцөл байдлыг шууд хүргэнэ.

3.2. Мэдээллийг хүргэхдээ зөвхөн мэргэжлийн үг хэллэг ашиглах.

3.3. Нийслэлийн Онцгой байдлын газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэс хяналт тавьж , удирдлага, арга зүйгээр ханган идэвхижүүлж ажиллана.

3.4. Нийслэлийн Онцгой байдлын газар, Гамшгаас хамгаалах сургалт аргазүйн төв, нийслэлийн Аврах анги 105, дүүргүүдийн ОБХ-ийн албан хаагч бүр тус фэйсбуук хуудасны идэвхитэй гишүүн байж, мэдээллийг олон нийтийн сүлжээгээр түгээх үүргийг хүлээнэ.

---оОо---